

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Бугат сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/5/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2022 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлан аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 106

танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
И.ПҮРЭВБАТ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020205

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:\bichigereg\2022A4\toot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,511,594.54	16,676,133.40
33	АВЛАГА	937,552.54	817,591.40
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	937,552.54	817,591.40
35	БАРАА МАТЕРИАЛ	15,574,042.00	15,858,542.00
354	Хангамжийн материал	15,574,042.00	15,858,542.00
35410	Бичиг хэргийн материал	50,000.00	-
35420	Аж ахуйн материал	15,524,042.00	15,858,542.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	29,488,812.30	26,911,856.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	29,488,812.30	26,911,856.25
392	Биет хөрөнгө	26,666,812.30	24,089,856.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,052,740.00	21,052,740.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(21,052,740.00)	(21,052,740.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,515,676.70	30,515,676.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,966,561.71)	(23,013,711.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,154,272.30	15,154,272.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,486,080.07)	(11,906,050.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	292,896.36	292,896.36
39215	Хуримтлагдсан элэгдэл	(146,448.12)	(256,284.21)
39217	Ном	13,303,056.84	13,303,056.84
393	Биет бус хөрөнгө	2,822,000.00	2,822,000.00
39301	Програм хангамж	50,000.00	50,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(50,000.00)	(50,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,822,000.00	2,822,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	46,000,406.84	43,587,989.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,481,940.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,481,940.00	-
413	Өглөг	4,481,940.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,481,940.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	41,518,466.84	43,587,989.65
51	Засгийн газрын хувь оролцоо	41,518,466.84	43,587,989.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	48,100,253.54	48,100,253.54
51101	Өмч: - төрийн	48,100,253.54	48,100,253.54
512	Хуримтлагдсан үр дүн	(62,670,322.40)	(60,600,799.59)
51210	Өмнөх үеийн үр дүн	(62,670,322.40)	(62,670,322.40)
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,069,522.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,088,535.70	56,088,535.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	46,000,406.84	43,587,989.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	139,743,800.00	110,182,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	239,200.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	239,200.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	239,200.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	135,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	104,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	139,504,600.00	110,182,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	57,237,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	57,237,300.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,267,300.00	110,182,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,267,300.00	110,182,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	98,594,642.98	108,112,477.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,594,642.98	108,112,477.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	87,921,931.53	72,091,051.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,601,847.46	43,523,457.04
210101	Үндсэн цалин	39,088,154.46	34,400,793.04
210102	Нэмэгдэл	10,513,693.00	9,122,664.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,237,788.25	5,370,166.32
210201	Тэтгэврийн даатгал	4,257,155.59	3,695,203.10
210202	Тэтгэмжийн даатгал	498,246.48	427,327.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	399,400.38	330,261.54
210204	Ажилгүйдлийн даатгал	274,330.77	91,720.50
210205	Эрүүл мэндийн даатгал	808,655.03	825,653.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,575,107.30	17,445,772.25
210301	Гэрэл, цахилгаан	425,667.30	296,332.25
210302	Түлш, халаалт	17,149,440.00	17,149,440.00
2104	Хангамж, бараа материалын зардал	839,000.00	1,827,600.00
210401	Бичиг хэрэг	63,000.00	366,500.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	152,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85,000.00	75,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	591,000.00	505,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	727,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	513,900.00	1,347,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	405,900.00	347,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,154,288.52	2,576,956.05
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,154,288.52	2,576,956.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,672,711.45	36,021,425.53

2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	35,991,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	35,791,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,422,711.45	30,425.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,422,711.45	30,425.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	41,149,157.02	2,069,522.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,149,157.02	2,069,522.81

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(46,582,179.42)	57,606,609.82
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(46,582,179.42)	57,606,609.82
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(16,088,142.98)	(16,088,142.98)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(62,670,322.40)	41,518,466.84
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(62,670,322.40)	41,518,466.84
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(62,670,322.40)	41,518,466.84
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2,069,522.81	2,069,522.81
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(60,600,799.59)	43,587,989.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	139,639,600.00	110,182,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	135,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	135,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	135,000.00	-

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	135,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	139,504,600.00	110,182,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	57,237,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	57,237,300.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,267,300.00	110,182,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,267,300.00	110,182,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	82,402,300.00	110,182,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,402,300.00	110,182,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,729,588.55	74,160,574.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,957,133.00	43,523,457.04
210101	Үндсэн цалин	39,411,206.00	34,400,793.04
210102	Нэмэгдэл	10,545,927.00	9,122,664.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,237,788.25	5,250,205.18
210201	Тэтгэврийн даатгал	4,257,155.59	3,575,241.96
210202	Тэтгэмжийн даатгал	498,246.48	427,327.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	399,400.38	330,261.54
210204	Ажилгүйдлийн даатгал	274,330.77	91,720.50
210205	Эрүүл мэндийн даатгал	808,655.03	825,653.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,093,167.30	21,927,712.25
210301	Гэрэл, цахилгаан	425,667.30	296,332.25
210302	Түлш, халаалт	12,667,500.00	21,631,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	298,500.00	321,500.00
210401	Бичиг хэрэг	50,500.00	56,500.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	63,000.00	-
2105	Нормативт зардал	135,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	135,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	361,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	65,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	296,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,708,000.00	2,776,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,600,000.00	1,776,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,672,711.45	36,021,425.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	35,991,000.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	35,791,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,422,711.45	30,425.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,422,711.45	30,425.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	57,237,300.00	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	57,237,300.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	116,422,000.00	110,151,574.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,422,000.00	110,151,574.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,431,000.00	74,160,574.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,455,300.00	43,523,457.04
210101	Үндсэн цалин	39,131,400.00	34,400,793.04
210102	Нэмэгдэл	9,323,900.00	9,122,664.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,309,000.00	5,250,205.18
210201	Тэтгэврийн даатгал	4,510,800.00	3,575,241.96
210202	Тэтгэмжийн даатгал	449,600.00	427,327.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	359,600.00	330,261.54
210204	Ажилгүйдлийн даатгал	89,900.00	91,720.50
210205	Эрүүл мэндийн даатгал	899,100.00	825,653.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,003,700.00	21,927,712.25
210301	Гэрэл, цахилгаан	321,700.00	296,332.25
210302	Түлш, халаалт	21,682,000.00	21,631,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	325,000.00	321,500.00
210401	Бичиг хэрэг	60,000.00	56,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	380,000.00	361,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	65,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	296,000.00
2107	Томилолт, зочны зардал	58,000.00	-

210702	Дотоод албан томилолт	58,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,900,000.00	2,776,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900,000.00	1,776,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	116,422,000.00	110,182,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	116,422,000.00	110,182,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	116,422,000.00	110,182,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ ороогүй болно.

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бугат сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн толилуулга, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/49 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүн ардад үзүүлэх соёлын үйлчилгээг өргөтгөх, урлагийн бүх төрлийг хөгжүүлэх, үндэсний соёлоо залуу өвдөө өвлүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн хөдөө нутгаа хөгжүүлэх эрэн үеийн хөгжлийн түвшинд хүрсэн зах зээлд өрсөлдөх чадвартай соёлын төв болох зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна. Зорилтынхоо хүрээнд "Бүтээмж-Чанарыг сайжруулах жил"-ийн ажил, Соёлын яамнаас "Бүтээлч сар" ажлыг зарласан, "Соёлын довтолгоо-2" цахим тоглолтуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу тайлант онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 98,597.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,397.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 978.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бугат сумын соёлын төвийн тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	937.60	817.60	(120.00)
Бараа материал	15,574.00	15,858.50	284.50
Үндсэн хөрөнгө	29,488.80	26,865.90	(2,622.90)
Нийт хөрөнгө	46,000.40	43,542.00	(2,458.40)
Богино хугацаат өр төлбөр	4,481.90	-	(4,481.90)

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	41,518.50	43,542.00	2,023.50
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	46,000.40	43,542.00	(2,458.40)

Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 110,182.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 110,151.6 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 30.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Авлага тайлант хугацаанд 817.6 мянган төгрөг болж, 120.0 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага төлөгдсөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15,858.5 мянган төгрөг болж, 284.5 мянган төгрөгөөр өссөн нь бүжгийн гутал, акустан хавтан, халуун хэмжигч, мантаажны утас, үдээсний машин зэргийг нөөцөлснөөс үүссэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 26,865.9 мянган төгрөг болж, 2,622.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Тайлант хугацааны эцэст түлш халаалтын өглөгийг бүрэн барагдуулан өллөггүй ажилласан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бичилт хийгдээгүй, тайлант оны хуримтлагдсан үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээнд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 105,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 5,182.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 110,182.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор төсвийн захирагчийн төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 3 чиглэлийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 110,182.0 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 110,182.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд 72,406.0 мянга, уран бүтээлийн зардалд 1,724.2 мянга, тэтгэвэрт гарахад болон нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 36,021.4 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 30.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 110,151.6 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 6,270.4 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,058.8 мянган төгрөгөөр буюу 16.8 хувиар, байр ашиглалттай холбоотой зардал 75.9 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар гүйлгээ ороогүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн 39201, 39203, 39205, 39207, 39214 дансанд нэр бүхий 41,689.2 мянган төгрөгийн хөрөнгө эзэмшилдээ байгаа элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна. Үлдэх өртөг тэг үлдэгдэлтэй ашиглалтын хугацаа бүрэн дууссан хөрөнгөнд нэмж элэгдлийн зардал байгуулагдахгүйгээс тухай тайлант хугацааны элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй дутуу тайлагнагдаж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 128 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба сар бүр 96 мэдээлэл, улирал бүр 4 мэдээлэл оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- ✚ Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

- ✚ Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

- ✚ Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналт хангалтгүй нь дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн актыг төлөөгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өөрийн эзэмшилдээ байгаа боловч хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн ашиглалтын хугацаа дууссан ч ашиглагдаж байгаа хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн шинэчлэн тогтоох, нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулалтын эрх нээхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,324.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6,883.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн үр дүнгийн тайланд 6,883.9 мянган төгрөгийн алдааг тусгаж баталгаажуулав. Үүнд:

- ✚ Элэгдлийн зардал – 2,622.9 мянган төгрөг,
- ✚ Цалин, ХХОАТ, НДШ-ийн зардал – 4,260.9 мянган төгрөг,

Энэ нь УСНББОУС 27-д “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, “Үнэн зөв толилуулга” нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг”, НББОУС 8-ын 10.Б.1-д “аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэл ба мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх” заалтуудтай нийцэхгүй, “эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тогтоогоогүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал.

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд авлага бууруулах ажил зохион байгуулаагүй, он дамжсан авлагатай ажилласан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Өмнөх оны төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт холбоотой асуудал.

2.1. Илрүүлэлт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоогдсон төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал.

3.1. Илрүүлэлт:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу 2020-2021 хичээлийн жилд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажиллаагүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, дотоод хяналт шалгалтын баг томилуулан ажиллуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Бугат сумын соёлын төв	5	8,324.9	3	6,883.8	0	0	0	0	2	1,441.1